# СҮХБААТАР АЙМГИЙН НАРАН СУМЫН 2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

## ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

-Хагас байдлаар дээд газраас 185 нийт албан бичиг ирснээс, хариутай бичиг 57 ирж, 45 албан бичгийн хариуг хугацаанд нь барагдуулж, хугацаа болоогүй 5, огт шийдвэрлээгүй 7 албан бичиг байна. Шиидвэрлэлт 78,9 хувь.

-Мөн хагас байдлаар нийт 33 эрх зүйн баримт бичиг ирснээс Аймгийн Засаг даргын Захирамж – 23, Аймгийн ИТХ-ын Тогтоол 4, Сумын ИТХ-ын Тогтоол 1, Аймгийн Засаг даргын албан даалгавар 2, Төрийн албаны зөвлөлийн тогтоол 1, Аймгийн Мал эмнэлгийн даргын тушаал 1 ирж, тус тус хэрэгжиж байна.

-Хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж хугацаатай бичгийн шийдвэрлэлтийн мэдээ, тайланг гаргаж дотоод чатад тавьж мэдээлж ажиллаж байна.

Дотоодын ажлын талаар:
2022 оны хагас жилийн байдлаар;
1.Сумын Засаг даргын А-Захирамж - 58
2.Сумын Засаг даргын Б-Захирамж - 19
4.Засаг даргын албан бичиг -41
5.ЗДТГ-ын даргын А-Тушаал - 10
6.ЗДТГ-ын даргын Б-Тушаал - 25
7.ЗДТГ-ын даргын албан бичиг -50
Нийт 31 албан бичгийг цахим шуудангаар болон сумын шуудангаар хүргүүлж ажилласан.

Хэвлэмэл хуудасны зарцуулалт:
1.Сумын Засаг даргын А-Захирамж - 120
2.Сумын Засаг даргын Б-Захирамж - 40
4.Засаг даргын албан бичиг -85
5.ЗДТГ-ын даргын А-Тушаал - 25
6.ЗДТГ-ын даргын Б-Тушаал - 50
7.ЗДТГ-ын даргын албан бичиг -100





2022 онд хөтлөгдөх, хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтыг батлуулсан

**Өргөдөл гомдлын талаар:**

2022 оны хагас жилийн байдлаар иргэдээс Засаг дарга болон Тамгын газрын дарга, холбогдох албан тушаалтнуудад хандаж 10 өргөдөл гомдол ирж шийдвэрлэгдсэн. Шийдвэрлэлт 100%

Төрийн албан хаагчдын нэгдсэн арга хэмжээг 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зохион байгууллаа. Уг арга хэмжээг сумандаа 4 дэх жилдээ зохион байгуулж байгаа бөгөөд нийт 97 төрийн албан хаагчид хамрагдсан. Аймгийн ЗДТГ-ын хүний нөөцийн мэргэжилтэн н.Оюунтөгс урилгаар хүрэлцэн ирж, алба хаагчдад мэдээлэл хийн, тулгамдаж буй асуудлыг ярилцлаа.












ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ЗӨВЛӨГӨӨН, СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

2022.03.00



Наран суманд анх удаагаа Наран сумын ЗДТГазар, "Баатар уулын хүчтэн" бөхийн холбоо хамтран Өсвөрийн бөхийн Аймгийн аварга шалгаруулах үндэсний бөхийн тэмцээнийг5 сарын 5,6-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж Тэмцээнд 11 сумын 13 сургуулийн 200-аад бөх, багш, дасгалжуулагчид амжилттай оролцлоо.






05-р сарын 21-ний өдөр Баяндулаан хайрханы тахилга, 06-р сарын 05-нд Ренцэндэрэм хадны тахилга болсон.



2022 он 03 дугаар сарын 17-ны өдөр сумын Цагдаагийн хэсэгтэй хамтран “Зөвийг зөвлөе” арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд 40 гаруй иргэд

хамрагдсан бөгөөд Архидан согтуурах гэмт хэргийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, болон хүрээлэн буй орчны гэмт хэргийн зөрчлөөс сэргийлэх эрх зүйн мэдээ мэдээллийг өгч нөлөөллийн ажлыг хийж гүйцэтгэсэн.







**<u>БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР</u>**

БҮТ - өөс явуулж байгаа "Гүйцэтгэлийн үнэлгээ" -ний шалгалтыг зохион байгуулах ажлын хэсгийг сургуулийн захирлын 2022. 05.16-ны өдрийн А\07 тушаалаар байгуулж, шалгалтыг хуваарийн дагуу 2022.05.24-нөөс эхлэн 1-9-р ангид дараах хуваарийн дагуу хичээлүүдийн шалгалтыг тус тус зохион байгуулсан. Хянагч багшаар сүхбаатар аймгийн НТБТ-ийн мэргэжилтэн Насанжаргал ирж ажилласан.



Байгууллагын ёс зүйн хорооноос багш ажилчдад "Багш-ажилчдын ёс зүй" сэдвээр сургалт зохион байгууллаа. 2022.05.27





Суралцагчийн хөгжлийн газар, Боловсролын Ерөнхий газраас хамтран зохион байгуулж буй "ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАМГААЛАХ НЬ" сэдэвт

сургалтанд 2022.06.07-08-ны хооронд 2 өдөр цахимаар дотуур байрны багш, нийгмийн ажилтан нар хамрагдлаа.





2022 оны 05-р сарын 31-ны өдөр 2021-2022 оны хичээлийн жилийн “Нэгдүгээрт хүүхэд” тайлант өдөрлөгийг зохион байгуулж,  нийт эцэг эхчүүдэд суралцагчид сурсан, мэдсэн зүйлээ тайлагнаж үзүүлэх ангийн массын тоглолтуудыг үзүүллж ажилласан нь хүүхдийн тэгш оролцоог хангасан гэж үзэж байна. Тайлангийн үеэр тухайн жилийн үйл ажиллагааг дүгнэх сэтгэл ханамжийн судалгааг “Хүүхэд хөгжил, хамгаалал”, “ Байгууллагын орчны эрүүл ахуй, аюулгүй байдал”, “Суралцагчдын суралцах үйл, ялгаатай байдал” гэсэн 3-н чиглэлээр авч үр дүнг нэгтгэж танилцуулан цаашид ажиллах алдаа дутагдлаа олж харсан ажил болсон.





**<u>ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР</u>**

Үндсэн үзүүлэлтүүд:
Нийт үзлэг-456
Урьдчилан сэргийлэх-159
Амбулаторт-97
Артерийн гипертензин эрт илрүүлэг-40
Чихрийн шижин эрт илрүүлэг-50
Жирэмсний хяналтад байгаа-10
Шинээр хамрагдсан-1
Жинэлсэн хүүхдийн тоо-22
Эмнэлэгт хэвтсэн-23
Дусал тариа-245
Судас тариа-210
Булчин тариа-85
Арьсан доорх тариа-22
Уян зүү-25
Катетр-2
Боолт-4

Хүчилтөрөгч-3
Сэргээн засах: Нил улаан туяа-54
Хэсэгчилсэн зөөлөн бариа-8
Бумба-8
Утлага-16
Холын дуудлага-18
Төвийн дуудлага-70

**Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээны талаар**

2022 оны 3 сарын 5 нд Төсөвт 5 байгууллагын нийт 78 албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэг болон элэгний В,С вирусын шинжилгээ, сахар, хеликобактерийн шинжилгээг авсан үүнээс В вирус эр-2 эм-2, С вирус эр-5, эм-3 эерэг гарч, эерэг гарсан ажилчдыг 2 дахь шатны эмнэлэгт үзүүлэхээр чиглүүлж, зөвөлгөө өглөө, сөрөг гарсан эр-16, эм-24 нийт-40 буюу 78/40/51,2% албан хаагчийг гепатит В-ын вакцинжуулалтад хамрууллаа.

2022 оны 3 сарын 7-18ныг хүртэл Ард иргэд аж ахуйн нэгжийн иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг болон элэгний В,С вирусын шинжилгээ, сахар, хеликобактерийн шинжилгээг авсан үүнээс В вирус- эр-2, эм-2, С вирус- эр-2 эм-0 эерэг гарч, эерэг гарсан иргэдийг 2 дахь шатны эмнэлэгт үзүүлэхээр чиглүүлж, зөвлөж сөрөг гарсан иргэдийг гепатит В-ын вакцинжуулалтад эр-18, эм-16, нийт-34 хүнийг хамруулан ажилласан.

2022 оны 2сарын 26, 27ны өдрүүдэд Хилийн 5,6-р заставын нийт-27 албан хаагч, цэргүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, ковид19 халдвараас сэргийлэх дархлаа сэргээх 3,4-р тунгийн вакцинжуулалтыг хийсэн.

 

Сургалт сурталчилгааны чиглэлээр

- 2022 оны 3 сарын 01 “Эрчүүдийн эрүүл мэндий
- 0н төлөө хамтдаа аян” нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж АБ, АЖАН, иргэд нийт-74 иргэн хамрагдсан.Нээлтийн үеэр:

- “Эртэч залуус” өглөөний цай хөтөлбөр
- “Элгээ хайрла”
- “Архи тамхины хор уршиг”-ын талаарх сургалт орж, эрчүүдэд тулгамдаж буй асуудлын талаар нээлттэй ярилцлага хийсэн.





**<u>ТӨРИЙН САНГЫН ЧИГЛЭЛЭЭР</u>**

2021оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд 3 сарын 5-нд хүргүүлэн аудит хийлгүүлж Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд нийт 10 тайлан нэгтгэгдсэн. Үүнд: төсөвт байгууллага-6, төрийн сангийн ерөнхий орлогын тайлан-1, хувийн хэвшил-1, ОНХСан, СХСан нийт 10 тайлан хүргэгдэж зөрчилгүй дүгнэлттэй ажилласан.

**ТӨСӨВ, САНХҮҮ ГҮЙЦЭТГЭЛ**;

Өмнөх онд 7392500 төгрөгийн авлагатай гарсан байна. 2392500 төгрөгийн авлагыг барагдуулж ажилласан.

Нийт батлагдсан төсөв -372678.7 төгрөг. Үүнээс 5-р сарын 31-ний байдлаар санхүүжилт өссөн дүнгээр -179475.8 гүйцэтгэл нь 146454.9төгрөг байна.

Батлагдсан төсвийн хүрээнд сар бүр ирсэн санхүүжилтийн хүрээнд ажилчдын цалин болон бусад тогтмол зардалуудын гүйлгээг анхан шатны баримтуудыг үндэслэн хийж гүйцэтгэсэн /1-5 сар/

Нэмэлт санхүүжилтийн дансанд /5-31ний байдлаар/ 77312.8 төгрөг орж ирсэний 18655.0 төгрөг нь өвс тэжээлийн орлого, бусад 58737.8 төгрөг нь ИОН ЭНЕРЖИ ХХК, 2021 оны усны үлдэгдэл мөнгө, Төрийн банкны халаалтын орлого тус тус орсон байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орж ирсэн мөнгийг тухай бүрд нь Аймгийн төрийн санд хүсэлт илгээж, 57397.8 төгрөгийн эрхийг тавиулж гүйлгээг хийж ажиллаллаа.

5-р сарын 31-ний байдлаар 31430.6 төгрөгийн зарлага гарсан байна.

**ШИЛЭН ДАНС;**

Сар бүр shilendans.gov.mn сайтаар орж байгууллагын мэдээллийг оруулан ажиллаж байна. Үүнд сар бүр оруулах хэсэгт -15, тухай бүр оруулах хэсэгт -43, улирал бүр оруулах хэсэгт -1, бүтэн жилээр оруулах хэсэгт 3 мэдээллийг тус тус оруулсан байна.

**МЭДЭЭ ТАЙЛАН**;

2021 оны 4-р улирлын татварын тайланг тайлант хугацаанд https:/tax.mta.mn/portal цахим хаягаар хийж илгээсэн.

Сар бүрийн НД-ын тайланг дараа сарын 5-ы дотор хийж НД-ын байцаагчаар хянуулан ажиллалаа. Шимтгэл татварын ямар нэгэн өргүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 2-ны дотор гаргаж Санхүү албаны даргаар хянуулан баталгаажуулж ажиллаж байна.

**ӨРИЙН МЭДЭЭ;**

1 сард шуудан холбоо -22390 төгрөгийн өр, 3 сард түлш халаалтын зардал дээр 665491.7 төгрөгийн өр үүссэнийг дараа сарын санхүүжилт орж ирэхэд барагдуулсан.

**Гүйцэтгэлээр:**

- **2021 оны татварийн орлогоор** он дамжсан ажил-50,4 сая

малын тэжээл – 800ш 20 сая Шарга ХХК

өвс нөөц – 30,4 сая 4000 боодол Баянцагааны Батхүрэл





**<u>ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР</u>**

6-р сарын 02,03 нд Сүхбаатар аймагт болсон хөдөө аж ахуйн тооллогын сургалтанд 2 тоологч,төрийн сангийн мэргэжилтний хамт хамрагдсан байна. Сумын хэмжээнд хөдөө аж ахуйн тооллогыг 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс 06 дугаар сарын 16-ны хооронд бүрэн тоолж,нэгтгэх тооллогын бэлтгэл,зохион байгуулалтын ажлыг сайтар хангаж ,хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг өрх,аж ахуйн нэгжийг тооллогод бүрэн хамруулан аргачлал,заавар журмын дагуу чанартай зохион байгуулах.




Хөдөө аж ахуйн тооллогд 1 болон 3-р багийн 64 өрх хамрагдсан байна.Үүнээс малтай өрх-54,мал бүхий-6,газар тариалантай өрх-4 тус тус тоологдсон байна.

Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг 1-р багийн нутагт нийт - 450 км явсан байна.




Сүхбаатар аймгийн Ханилаг ХХК,Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын тамгын газартай байгуулсан гэрээний дагуу Сэлэнгэ үүлдрийн 8 /найман / толгой бяруун бухыг хүлээн авлаа.

Үржлийн бухны гэрчилгээ,мал эмнэлэгийн ажил үйлчилгээний гэрчилгээ Анги чанар

хувьслын ангилалтаар жишигт тэнцсэн тул үржилд ашишлах гэрчилгээ олгосон байна.





Зүүн бүсийн аймгуудийн малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан,түүний дэд сангуудын нэвтрүүлэлтийн сургалт Хэнтий аймагт зохион байгуулагдлаа.Хүнс хөдөө аж ахуй,хөнгөн үйлдвэрийн яамнаас 2022.06 дугаар сарын 23-ны өдрийн 09-13 цагийн хооронд Мал аж ахуйн салбарын нэгдсэн системийг ашиглах программ дээр ажиллах дадлагыг сумдын хөдөө аж ахуйн тасгийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт,менежмент,малын үржил,бүртгэлтйн асуудал хариуцсан мэргэжилтэн,мал үржүүлэг технологийн ажил,үйлчилгээний нэгжийн дарга,мэргэжилтэнүүдэд зориулсан онлайнаар зохион байгуулсан сургалтанд цахимаар оролцлоо.




**<u>Соёлын чиглэлээр</u>**

Монгол үндэсний шагайн харвааг сурталчилах, шагайн харвааны уламжлалт соёлыг залуу хойч үедээ өвлүүлэх зорилгоор Аймгийн аварга шалгаруулах сорилго тэмцээнийг явуулж 8 багийн 48 хүн оролцсон.




Залуу ардын авьяастан Л.Соронзонболд, Х.Хатантөмөр нарын “Нутгийн түмэндээ” тоглолт, Ардын авьяастан Э.Бөхчулуун, Э.Амарбаатар нарын “Амин хэлхээ” тоглолтыг тус тус бэлтгэн ард иргэдэд хүргэсэн.






Байгууллага сурталчилах сарын аяныг 03 дугаар сарын 18-ны өдрөөс 04 дүгээр сарын 18-ны хооронд зохион байгуулсан. Энэхүү ажлын нээлтийн арга хэмжээг 03-р сарын 18-ны өдөр хийж Цагдаагийн байгууллагын мэдээлэл, хөзөрийн боосоот тэмцээн, үдшийн цэнгүүнийг зохион байгууллаа. Байгууллага сурталчилах аяны хүрээнд 04-р сарын 08-ны өдөр волейболын тэмцээн, “Үдшийн цэнгүүн” зэрэг үйл ажиллагааг зохион байгууллаа.

Аймгийн ХЖТеатрын “Хайрын бэлэг” аялан тоглолтыг хүлээн авлаа.

“Сүхбаатар-80” урлагийн наадамд бэлтгэж байгаа тоглолтоо 05-р сарын 02-ны өдрийн 18 цагаас иргэд хөдөлмөрчидөд тоглолоо. Хүүхэд 156, том хүн 102 үзсэн.





5 дугаар сарын 5,6-ны өдрүүдэд Баруун-Урт хотноо зохион байгуулагдах “Сүхбаатар-80” урлагийн наадмын бэлтгэл ажлыг эхлүүлэн, Дорноговь, Хэнтий аймгаас дуу хөгжмийн болон бүжгийн багш урьж авчирч, сумын Засаг даргаар захирамж гаргуулан, 39 ардын авъяастан, уран сайханчдаас бүрдсэн “Нар тоссон аялгуу” тоглолтыг амжилттай тавьлаа. Наадамд оролцсон бүтээлүүдээс язгуур урлагийн төрөлд оролцсон ардын авъяастан Б.Мөнхсайхан, Соёлын төвийн хөгжмийн багш Л.Чинбат нар, мөн хамтлаг хөгжим төрөлд тус тус Соёл, урлагийн газрын даргын нэрэмжит шагналаар шагнууллаа.






**ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ**

**ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН М. БЯМБАСҮРЭН**